



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/497

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг үндэслэн "Үйлдвэрлэгч-Ховд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Үйлдвэрлэгч -Ховд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор төсөл сонгон шалгаруулалт явуулсан дүн, байгуулсан гэрээ, санхүүжилтийн эрхийг үндэслэн хавсралтанд заасан аж ахуйн нэгжүүдэд зээл олгосугай

2. Зээл олгох аж ахуйн нэгжийг хавсралтаар баталсугай

3. Дээрхи арга хэмжээнд зарцуулах 173.0 сая /Нэг зуун далан гурван сая/ төгрөгийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8/04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт орон нутгийн хөгжлийн сангийн 5.31-д заасан "Үйлдвэрлэгч -Ховд" өрхийн жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн санхүүжилтээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга / Ч.Багдал /, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/ нарт зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



02-00479

Аймгийн Засаг даргын 2019 оны
08 дугаар сарын 01-ний өдрийн
А/497 дугаар захирамжийн хавсралт



“ҮЙЛДВЭРЛЭГЧ-ХОВД” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
ЗЭЭЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭР

Д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Төслийн нэр	Хүссэн зээл	Олгох зээл
1.	“Эко гутал” ХХК	Эко гутал	150.000.000	100.000.000
2.	“Буянт үйлийн шим” хоршоо	Ажлын хувцасны үйлдвэр байгуулах	120.000.000	60.000.000
3.	“Тарвагатайн бэлчир” ХХК	Гагнуурын үйлдвэрлэл, үйлчилгээ	20.000.000	13.000.000
	Нийт дүн	3 төсөл		173.000.000

-oOo-